

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2022.02.14

Дугаар 20

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт ирүүлэх хугацаа	Биелэлт
1	Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага болон орон сууцанд амьдардаг айл, өрхүүдийн нэгдсэн халаалтын түгээлтийн чанарт шалгалт хийх ажлын хэсэг ажиллуулах, дүгнэлт гаргах	Аймгийн МХГ Аймгийн ОБГ Аймгийн ГХБХБГ	II/17	
2	Аймгийн Цагдаагийн газрын байрны 3 давхрын өргөтгөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Гадаадын иргэн, харьяатын газрын шинэ барилгын зураг төсвийг бэлэн болгох, газрын асуудлыг шийдвэрлэх	ГХБХБГ-ын дарга К.Болат	II/17	
3	E-Mongolia платформын хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийг оролцуулан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн ажлыг сурталчлах өдөрлөг зохион байгуулах, дүнг Засаг даргын зөвлөлд танилцуулах	Аймгийн ГХБХБГ Аймгийн УБХ Аймгийн НДХ Аймгийн ЭМДХ	II/17	
4	Байгууллага болгон хүний нөөцийн төлөвлөлт, томилгоонд хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулан, илэрсэн зөрчил дутагдлыг нэн даруй засах арга хэмжээ авах. ТАЗ-ийн 411 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, түр буюу сонгон шалгаруулалтгүйгээр томилогдсон ажилтнуудыг нэн даруй чөлөөлөх арга хэмжээ авах	Нийт байгууллага, агентлаг	II/17	
5	Хөрөнгө орлогын мэдүүлэг баталгаажуулаагүй ЭБАТ, мэдүүлэг гаргаагүй албан тушаалтны мэдүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөрт багтаан гаргуулах, баталгаажуулах	Нийт байгууллага, агентлаг	II/17	
6	Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дугаартай захирамжийн биелэлт хангалтгүй, буруу албан даалгаврын биелэлтийг гаргаж ирүүлсэн байх тул биелэлтийн тайланг дахин гаргаж, аймгийн ЗДТГ-т бичгээр ирүүлэх	Нийт байгууллага, агентлаг	II/17	
7	АТГ-аас байгууллагуудын мэдээллийн ил тод байдал, шилэн дансны хөтлөлтөд үнэлгээ хийх болсон тул мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг зохих ёсоор байршуулах, олон нийтэд хүргэж, хяналтын ажлын хэсэгтэй хамтран ажиллах	Нийт байгууллага, агентлаг	II/17	
8	Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаж аймгийн ЗДТГ-т ирүүлэх.	Нийт байгууллага, агентлаг	II/17	
9	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Өлгий сумын 9 байршил, 100 гаруй га талбайд мод тарих шийдвэр гарсан тул мод тарих газруудыг төрийн байгууллагуудад хуваарилах, мод тарих, арчлах, ургуулах үүргийг хариуцуулах	Өлгий сумын ЗД Д.Есболат БОАЖГ-н дарга Ш.Марат СДОА-н дарга Н.Есенбол	II/17	

10	Ард иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гол, нуурын мөсөн дээгүүр зорчихгүй байх, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэх.	Аймгийн ОБГ-ын дарга З.Азат АШШтаб	II/17	
11	Коронавируст халварын төлбөрт шинжилгээний цэгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, иргэдэд мэдээлэл өгөх.	Аймгийн ЭМГ-ын дарга Н.Сакен Аймгийн МХГ-ын дарга Х.Бауыржан	II/17	
12	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг Коронавируст халдварын шинжилгээнд хамруулах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааны талаарх танилцуулгыг бэлтгэн аймгийн ЗДТГ-т ирүүлэх.	Аймгийн БГ-ын дарга Г.Амантай	II/17	
13	Наурызын баярыг зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулж, батлуулан нийтэд мэдээлэх	ХЭЗХ-ийн дарга Ө.Хуралай, СУГ-ын дарга К.Бекжан, БОАЖГ-ын дарга Ш.Марат БТСГ-ын дарга Х.Хайнар	II/17	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР